



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/363

Арвайхээр сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.5.2. дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсад 2024 оны 5 дугаар сарын 29-өөс 6 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдах “Боловсролын салбар дахь цахим шилжилт, технологийн дэвшил” олон улсын арга хэмжээнд оролцох Арвайхээр сумын ерөнхий боловсролын “Мэргэд” сургуулийн 11 дүгээр ангийн сурагч И.Нацагдоржийн зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй:

2.Дээрх 1,000,000 (нэг сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0746

D:My Doc. Zahiramj. Zasag darga